



ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

О.ҮЗМЭЭ

ХЯНАСАН:
ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ОТГОНБАЯР

2024-11-20

“Алсын хараа”

Дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ
Дэлхийн түвшинтэй хөл нийлүүлнэ

“Эрхэм зорилго”

Төрийн бүртгэлийг төгөлдөршүүлж
Улсын бүртгэлийг ухаалагжуулж
Цаасан бүртгэлийг цахимжуулж
Иргэдэд ээлтэй байгууллага байна


Орхон аймгийн
Улсын бүртгэлийн хэлтэс

“Уриа”

Эхээс мэндэлж нэрээ авахаас
Эх дэлхийдээ шингэн үдүүлэх
Уудам орон зүйд бид үйлчлэнэ
Улсын бүртгэл тантай хамт


“Чанарын бодлого”

Хууль тогтоомжийг чухалчилж
Хүний эрхийг дээдэлж
Үйл ажиллагаагаа сайжруулж
Үйлдэл бүхнээ хянаж
Чадвар ёс зүйгээр манлайлж
Чадамж гүйцэтгэлээр тэргүүлж
Түмэн хэрэглэгчийг хамруулсан
Төрийн санах ой байна.



НЭГ. ХҮНИЙ НӨӨЦ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР


2024 оны жилийн байдлаар Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь төрийн захиргааны албан хаагч 18, төрийн үйлчилгээний албан хаагч 5, байнгын гэрээт албан хаагч 2, түр гэрээт албан хаагч 4 нийт 29 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна.



- Албан хаагчдын эрүүл мэндийн асуудалд анхаарч урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 29 албан хаагчийг бүрэн хамруулж холбогдох албан хаагчид эмчилгээнд хамрагдлаа.



- Бүтэц зохион байгуулалт удирдлагын түвшинд хэлтсийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах асуудлын хүрээнд үйлчлүүлэгчдийн дунд санал асуулга авлаа. Санал асуулгаар үйлчилгээ авч буй иргэдийн 80% нь бүртгэгчийн харилцааны ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний танхимын хүрэлцээ тав тухыг сайжруулах олон дахин явуулахгүй нэг удаа асуудлыг шийддэг байх саналыг гаргасан байна. Хэрэглэгч үйлчилгээ авахын тулд интернэт болон цахим үйлчилгээний талаар судалдаггүй баримт бичгийн бүрдэл дутуу, ирж очихдоо бухимдал төрүүлдэг тухай дурджээ.



- Албан хаагчдын хүсэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор төрийн албаны тухай хуулийн дагуу мерит зарчмаар дэвшүүлэн томилсон 2, мөн гэрээтээс түр орон тоонд дэвшүүлэн томилсон 2, ангилал зэрэглэл ахиулсан 3 албан хаагч байна. Байгууллагын үйл ажиллагаа цэгцтэй дүрэм журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд дүрэмт хувцас өмсдөг, дэг журамтай ажиллаж ирлээ.



- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан бүсийн сургалт семинарт тус хэлтсийн 7 албан хаагч амжилттай сайн оролцсон төдийгүй удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж хариуг тухай бүр нь хүргүүлсэн.



- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөр, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Сархиа уулын энгэрт 2024 онд 45 ширхэг агч моднуудыг тарьж цэнэг усалгаа арчилгааг хийж ажиллалаа.



- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Бүртгэлийн тухай хууль, журам, Цахим бүртгэлийн тухай иргэд аж ахуй байгууллагуудад орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сайтуудаар 11 удаа, хэвлэлийн бага хурлыг нэг удаа тус тус зохион байгуулж иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.




- Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2024.05.01-ны өдөр Зэст багийн нэгдсэн байр “Хууль зүйн туслалцааны төвд” жил бүр зохион байгуулагддаг Хуульчдын “Про боно” өдөрлөгт 3 бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ, мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.




- 2024 оны 04 сарын 04-ны өдөр тус хэлтэс нь “Хотын их цэвэрлэгээ”-нд нэгдэж “Найрамдал” өндөрлөг орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэлээ.



- 2024 оны 03 сарын 28-ны өдөр Гамшгийн үеийн зарлан мэдээлэх дохиогоор хэлтсийн хамт олон идэвхтэй оролцлоо.



- Төрийн албаны ерөнхий шалгалт 2024 оноос жилд 4 удаа зарлагдаж тус хэлтсийн иргэний улсын бүртгэгч М.Жавзансүрэн, Б.Мөнхтуяа, Н.Алтанцэцэг болон Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн нар шалгалтад орох иргэдийн бүртгэлийг хурууны хээгээр таниулан бүртгэж ажиллалаа.



➤ **Албан хаагчдын сургалтын талаар**

Хүний нөөцийн системийн сургалтууд, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд, Аймгийн засаг даргын тамгын газраас болон төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй сургалтуудад нийт албан хаагчдыг тухай бүр бүрэн хамруулж үнэлгээ, сорил шалгалтуудыг бүх албан хаагчид хугацаанд нь өгч үнэлгээ авч байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 57 сургалт гадна болон хэлтсийн дотоод нөөц боллоцоогоо ашиглан зохион байгуулагдсан байна.

Д/д	Зохион байгуулагдсан сургалтын хамрах хүрээ	Сургалтын тоо
1	Хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой	4
2	Иргэний улсын бүртгэлтэй холбоотой	2
3	Архивч, бичиг хэрэг, нягтлантай холбоотой	4
4	Удирдах албан тушаалтны	2
5	Монгол Улсын Их хурлын Сонгуультай холбоотой	4
6	АНСДИТХ-ын сонгуультай холбоотой	4
7	Төрийн албаны зөвлөлийн сургалт	15
8	Мэдээлэл технологийн чиглэлээр	4
9	Бусад чиглэлээр	10
10	Дотооддоо зохион байгуулсан	8
Нийт		57

Дотоодод зохион байгуулсан сургалтын тухай:


№	Сургалт орсон албан хаагч	Сургалтын агуулга	Зураг
1	Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын тухай	
2	Дотоод аудитор, мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн	“Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015-ны үндсэн ойлголт, стандарт гэж юу вэ?” сэдэвт сургалт, танилцуулга	
3	Дотоод аудитор, мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн	“Чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтыг хянан шалгах, дотоод аудит хэрхэн хийх болон журмын хэрэгжилтыг хангах” тухай	
4	Иргэний улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч Ө.Ганзориг	“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт”-ийн талаар 2 удаагийн сургалтыг хэлтсийн хамт олонд орсон.	
5	Иргэний улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч О.Үзмээ	АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн тухай	
5	Иргэний улсын бүртгэгч Н.Алтанцэцэг	“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” (шинэчилсэн найруулга) -ийн танилцуулга сургалт	

<p>6</p>	<p>Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Хамралт, орлого, шимтгэл өр хариуцсан улсын байцаагч Н.Хулан</p>	<p>"Нийгмийн даатгалын багц хууль"-ийн тухай</p>	
<p>7</p>	<p>Орхон аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч Л.Отгонцэцэг</p>	<p>Хэлтсийн дэргэдэх "Эцэг эхийн зөвлөл" -өөс санаачлан "Хүүхэд хамгааллын тухай хууль, байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны талаарх мэдээлэл өгөх "Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга" сургалт</p>	
<p>8</p>	<p>Боловсрол, судлалын ухааны доктор, проф М.Толя</p>	<p>Улсын бүртгэлийн ажилтын өдрийг угтаад Иргэний улсын бүртгэлийн тасгаас санаачлан "Хүн байхын утга учир" (Зөв хүний эрэл) сэдэвт лекц сургалт</p>	 


ХОЁР. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **20022** бүртгэл хийгдсэн байна. Үүнд:


- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 13812,
- Газрын бүртгэл 6210,
- Бүртгэл хийхээс 320 мэдүүлэг татгалзсан болно.



- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:



- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:



ГУРАВ. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

➤ Тоон гарын үсэг олголтын талаар

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн дагуу 2024 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дугаар сарын 01-ны өдрийн хооронд Орхон аймгийн хэмжээнд олговол зохих **73598** иргэнээс тайлант хугацаанд **31553** тоон гарын үсэг буюу **42,8%** нь олгоод байна.

2022-2024 онуудад тоон гарын үсэг олгосон тоон мэдээ

Огноо	Нийт	Иргэний үнэмлэх	Мобайл апп	Эр	Эм	16 – 24 нас	25 – 44 нас	45 – 60 нас	60 – с дээш
2022 он	14686	11637	3049	7353	7333	684	8149	5227	626
2023 он	9935	4054	5881	4586	5349	998	5355	2975	607
2024 он	6932	380	6552	3265	3667	784	3329	2004	815
Нийт	31553	16071	15482	15204	16349	2466	16833	10206	2048

➤ Иргэний үнэмлэх олголтын талаар

Тайлант хугацаанд нийт 3963 бүртгэл хийгдэж 7926 хуудас ИУБ маягтыг цахимжууллаа. Мөн 5307 иргэнд иргэний цахим үнэмлэх хийгдсэн байна. Үүнээс:

№	Иргэний цахим үнэмлэхийн бүртгэл	Тоо	
1	16 нас хүрч шинээр олгогдсон үнэмлэх	1825	
2	Дахин олгосон үнэмлэх	1265	
3	Гадаадад	22	
4	Хугацаа дуусч солиулсан	25 нас хүрч	1059
		45 нас хүрч	1136
Нийт		5307	

➤ Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар


Тайлант хугацаанд нийт **2821** бүртгэлийн **11579** хуудсыг бүрэн цахимжууллаа.

Иргэний гэр бүл байдлын 8 бүртгэлийн чиглэлээр нийт **1381** бүртгэл хийгдэж **30127** хуудас материалыг бүрэн цахимжууллаа. Үүнд:

- Төрөлт 1530,
- Гэрлэлт 391,
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 183,

- Хүүхэд үрчлэлт 34,
- Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 85,
- Эцэг тогтоосны бүртгэл 78,
- Нас барсны бүртгэл 520

Мөн сар бүрийн тайлан, мэдээ болон ИУБ маягтуудыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.



➤ **Үндэсний энгийн гадаад паспорт олголтын талаар**

2024 оны жилийн эцсийн байдлаар **9569** иргэний үндэсний энгийн гадаад паспорт захиалгын бүртгэл хийгдсэн. Үүнд:

- Цахим гадаад паспорт 8569 иргэнд,
- Энгийн гадаад паспорт 1000 иргэнд олголоо.

Мөн цахим гадаад паспортын 664,0 сая төгрөг, энгийн гадаад паспортын 35,0 сая төгрөг болон улсын тэмдэгтийн хураамжийн 47,8 сая төгрөг нийт 746,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

➤ **Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар**

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын дагуу 2024 оны 11 сарын 18-ны өдрийн байдлаар нийт **7235** шилжилт хөдөлгөөний бүртгэл бүртгэгдсэн байна.

Д/д	Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн төрөл	Насанд хүрсэн иргэн	0-16 насны хүүхэд	Нийт
1	Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	1832	1199	3031
2	Сум, баг хооронд шилжин ирсэн	5403	3989	9392
Нийт		7235	5188	12423

ДӨРӨВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны жилийн эцсийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **1970** бүртгэл хийсэн ба цахимаар <https://e-business.mn/home> системээр **1642** хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажилт хийж ажиллалаа.

Үүнд:

Д/д	Бүртгэлийн төрөл		Бүртгэлийн тоо мэдээ	Нийт бүртгэгдсэн тоо
1	Шинээр байгуулагдсан хуулийн этгээд	Шинээр байгуулагдсан ХХК	258	358
2		Төрийн бус байгууллага	33	
3		Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	2	
4		Хоршоо	58	
5		Нөхөрлөл	3	
6		Төрийн байгууллага, албан газар	3	
7		Боловсрол сургалтын газар	1	
8	Мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах		616	1612
9	Хяналтын дугаар олголт		465	
10	Хууль хяналтын байгууллагад олгосон лавлагаа		219	
11	Иргэн хуулийн этгээдэд олгосон лавлагаа		93	
12	Дахин гэрчилгээ авсан		120	
13	Татан буугдсан		21	
14	Шилжиж ирсэн		17	
15	Хориг тавьсан		3	
16	Хориг цуцалсан		6	
17	Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл		10	
18	Салбар төлөөлөгчийн газрын өөрчлөлт бүртгэгдсэн		16	
19	Өөрчлөн зохион байгуулсан		2	
20	Хэлбэр өөрчлөгдсөн		24	
21	Цахимаар https://e-business.mn/home системээр олгосон нэрийн баталгаажуулалт		1642	
НИЙТ			3612	

**ТАВ. АЛБАН БИЧГИЙН ЭРГЭЛТ, ТУШААЛ, ШИЙДВЭР,
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР**

➤ **Албан бичгийн эргэлтийн талаар**

Тайлант хугацаанд тус хэлтэст нийт **1441** албан бичиг ирснээс хариутай бичиг **1034** байна. Хууль хяналтын байгууллагад 661 лавлагаа, тайлбар хүргүүлэн ажилласан. Тухайн хариутай бичгийг цаг хугацаанд нь хариуг хүргүүлсэн байна.

Ирсэн бичгүүдийг ангилан авч үзвэл:

Д/д	Албан бичиг ирүүлсэн байгууллагийн нэр	Тоо	
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	290	Тушаал 8 Үүрэг даалгавар 40
2	Цагдаагийн байгууллага	179	
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	280	
4	Шүүх	202	
5	Орхон аймгийн Засаг даргын тамгын газар	66	
6	Бусад байгууллагаас	424	
Нийт		1441	

➤ **Тушаал шийдвэр, хурлын тэмдэглэлийн талаар**

Д/д	Тушаалын, тэмдэглэлийн төрөл	Хөтлөгдсөн тоо
1	А тушаал	23
2	Б тушаал	7
3	Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	7
4	Хамт олны хурлын тэмдэглэл	3
5	Хэлтсийн шуурхай хурлын тэмдэглэл	25
Нийт		65

➤ **Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн талаар**

Тайлант хугацаанд иргэдээс нийт 28 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллалаа.

Мөн албан хаагчдаас 15 хүсэлт ирснийг хүлээн авч бүрэн шийдвэрлэсэн.

Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:

Д/д	Өргөдөл гомдлын төрөл	Тоо	Нийт тоо
1	Өргөдөл	0	28
	Хүсэлт	23	
	Гомдол	4	
	Талархал	1	
	Санал	0	

2	Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр	Бичгээр	17	28
		Утсаар	7	
		Засгийн газрын 1111	4	
3	Өргөдөл гомдлын агуулга	Иргэний бүртгэлийн чиглэлээр	3	27
		Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр	5	
		Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр	0	
		Бусад /Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт/	19	

ЗУРГАА. ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

2024 оны хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.



- Иргэний улсын бүртгэлийн **5772**,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн **480**,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн **950**,

нийт **7202** бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж, сар бүрийн тоон мэдээг Хяналт, шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2024 онд хяналт, шалгалтаар 6 бүртгэлийн 11 зөрчил илрүүлсэн ба зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан.

Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгө эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчилтэй холбоотой нийт 114 өргөдөл, гомдлыг хүлээн авсан. Үүнээс:

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 29,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 85 гомдлыг хуульд заасан журмын дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн, зөрчлийг бүрэн арилган шийдвэрлэж, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.



➤ 2024 оны жилийн эцсийн байдлаар Зөрчил шалган шийвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 155 иргэн, 4 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн 6025000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэн хуулийн хугацаанд нь прокурорт хянуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

➤ Хэлтсийн иргэний улсын бүртгэлийн цахимжуулах ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт 24830 бүртгэл 8697 хуудас цахимжуулалтад хяналт тавьж ажилласан.

Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн мэдээлэл бүрэн, бичилтийн шаардлагыг хангасан, эх хувьтай таарч байх бөгөөд ХААТР маягтад бичигдсэн мэдээлэл бичилтийн шаардлага хангасан, нотлох баримтын бүрдлийн шаардлага хангасан алдаа, зөрчилгүй байна.

➤ Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр бүртгэгдсэн 5772 бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд тухайн бүртгэлийн нотлох баримт бүрэн гүйцэд цахимжиж бүртгэсэн эсэхийг түүвэрчлэн шалгахад гэрлэсний, гэрлэлт цуцласны, нас барсны зэрэг 6 бүртгэлийн эх нотлох баримтыг улсын бүртгэгч цахимжуулсан байх боловч цахимжуулалт харагдахгүй зөрчил илэрсэн.

➤ Мөн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 950 бүртгэлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн гүйцэд цахимжсан эсэхийг түүвэрчлэн шалгахад өмчлөх эрхийн гэрчилгээний хуулбарыг цахимжуулаагүй 5 зөрчил илэрсэн.

➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 480 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсан зөрчил илрээгүй болно.

➤ Хяналт шалгалтанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийг таниулах, энэ төрлийн зөрчлийг давтан гаргуулахгүй, урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага, санамжийг бэлтгэн 20 хуулийн этгээдэд тараан өгч, Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, Зөрчлийн тухай хуулийг сурталчлах арга хэмжээг авч ажилласан.

ДОЛОО. САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- **Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн хөрөнгө үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулна.**

Жилийн байдлаар тус хэлтэст Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн 5 арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд дээрх арга хэмжээг санхүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 832,9 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн 263,1 сая төгрөг, нийт 1,097,5 сая төгрөгийн төсвийн зарцуулалтын эрх нээгдсэн. Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, зардлын бүлэг зүйлийн дагуу хугацаанд нь зарцуулан ажиллаж байна.

Батлагдсан төсөв, зарцуулалт / арга хэмжээ тус бүрээр /төгрөгөөр/

№	Арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Хэтрэлт /хэмнэлт/
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	832.00	737.07	94.93
2	Туслах үйл ажиллагааны зардал	163.40	144.80	18.60
3	Ажил олгогчоос тэтгэмж	0.48	0.20	0.28
4	МУИХ-ын сонгуулийн зардал	57.13	57.13	-
5	АНСДИТХ-ын сонгуулийн зардал	44.48	44.48	-
Нийт дүн		1,097.49	983.68	113.81

➤ **Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт**

Тус хэлтэс нь 2024 онд 320.0 сая.төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 434.3 сая төгрөгийг сар бүр хугацаанд нь төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 135,7 хувьтай байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлт / 2017 – 2024 он / сая төгрөгөөр

№	Тайлант он	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлт /Хувь/
1	2017.12 сар	320	345.7	108.03%
2	2018.12 сар	320	367.7	114.91%
3	2019.12 сар	320	331.4	103.56%
4	2020.12 сар	320	280.5	87.66%
5	2021.12 сар	320	359.19	112.25%
6	2022.12 сар	320	334.1	104.41%
7	2023.05 сар	320	347.1	108.47%
8	2024.10 сар	320	434.3	135.70%


➤ **Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд ерөнхий газарт хүргүүлнэ.**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст дараах нэр төрлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай хууль”-д заасан хугацаанд нь сар, улирал бүр цахим шуудангаар болон шаардлагатай тохиолдолд эх хувиар нь хүргүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас орон даяар явагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого”-д хуулийн хугацаанд бүрэн хамрагдан Өмч эзэмшүүлэх гэрээг “**96 ХУВЬ БҮЮУ САЙН**” дүгнүүлсэн болно. Мөн түүнчлэн ашиглалтын хугацаа дууссан элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг актлуулах саналыг тухай бүр Санхүү,аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

➤ **Хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, ноцтой зөрчил илэрээгүй байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2024 оны 02 дүгээр сарын 01-ны өдөр Орхон аймаг дахь Төрийн Аудитын газарт



хүргүүлсэн бөгөөд 2023 оны 02 дугаар сарын 22-ны өдөр “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” санал дүгнэлт авсан болно.

2023 оны Санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдөр гарган Аймаг дахь Төрийн Аудитын болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газар тус тус хүргүүлсэн болно.



➤ **Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал**

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 онд орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээний хүрээнд Орхон аймгийн Засаг даргын нөөц сангаас 4 гэрээт албан хаагчийн цалин болох 27.1 сая төгрөгийн санхүүжилт, Хөдөө орон нутгийн нэмэгдэл цалин 150,1 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй чирэгдэлгүй хүргэх зорилгоор 4G зөөврийн тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэн зорилтот бүлгийн иргэдэд, нээлттэй хаалга, албан байгууллагуудад хүрч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Бүртгэгч нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Аймгийн тамгын газарт хүсэлт гаргаснаар иргэний улсын бүртгэгч М. Жавзансүрэн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Баярмаа нарыг Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрууллаа.

НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛСАН ШИНЭЛЭГ АЖИЛ

Д/д	Шинээр санаачилсан ажил	Зураг
1	Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлөөс санаачлан албан хаагчдад зориулсан зөвлөмжүүдийг бэлтгэн хүргүүлэн ажиллалаа.	
2	Хууль хяналтын байгууллагуудын дунд “Волейбол”-ын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж тус хэлтсийн баг тамирчид “Дөтгөөр” байр эзэллээ.	
3	Аймгийн Засаг даргын тамгын газрын иргэдэд үйлчлэх 24/7 Цахим төвд үйлчилгээний Дөт киоск машин байршуулан 6695 иргэнд, хэлтсийн үйлчилгээний танхимд нэг Дөт киоск машин байршуулан 3677 иргэнд тус тус цаг хугацаа орон зай харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	

<p>4</p>	<p>“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-г угтан хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгууллаа.</p>	
<p>5</p>	<p>Иргэний улсын бүртгэлээр 8 ширхэг видео контент бэлтгэн олон нийтэд сурталчилсан.</p>	
<p>6</p>	<p>Иргэний улсын бүртгэлээр нийгмийн сүлжээнд 3 удаа шууд лайв хийж хуулийг олон нийтэд сурталчилсан.</p>	

<p>7</p>	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээр 7 ширхэг видео контент бэлтгэн олон нийтэд сурталчилсан.</p>	
<p>8</p>	<p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлээр 1 ширхэг видео контент бэлтгэн олон нийтэд сурталчилсан.</p>	
<p>9</p>	<p>Авлига, хүнд суртлаас ангид байх тухай 1 ширхэг видео контент бэлтгэн олон нийтэд сурталчилсан.</p>	

<p>10</p>	<p>Хэлтсээс Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн талаар мэдээ мэдээллийг ХЭЗХ-ын Хуулийн цаг нэвтрүүлэгээр иргэд олон нийтэд сурталчилан ажиллалаа.</p>	
<p>11</p>	<p>Хэлтсийн хамт олон “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяны хүрээнд өдөр бүр дасгал хөдөлгөөн хийж даралтны аппаратаар хэмжилт хийж тэмдэглэл хөтөлж хэвшсэн.</p>	
<p>12</p>	<p>Албан хаагч нарын сонголтоор иогын дасгал, фитнеснээр хичээллэж хөдөлгөөний дутагдлаас сэргийлж байна.</p>	
<p>13</p>	<p>Иргэдэд бүртгэлийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор бүртгэгч нарыг цайны цагаар ажиллуулж /дотоод зохион байгуулалт хийж/ байгаа нь иргэдийн талархлыг хүлээсэн ажил болсон.</p>	
<p>14</p>	<p>Үндэсний цахим болон энгийн гадаад паспорт, иргэний цахим үнэмлэх олголтыг LIME дугаар үүсгэн аппликейшн ашиглан эздэд нь мэдээлэл хүргэж байгаа нь иргэдэд хүрсэн шинэлэг ажил боллоо.</p>	

<p>15</p>	<p>Хэлтсийн албан хаагчид нь өөрсдийн санал санаачилгаар хүүхдийн өрөө нээж тохижилтыг хийж үйлчлүүлэгч иргэдэд тав тухтай үйлчилгээ авах, хүүхдүүдээ сургууль цэцэрлэгт өгөх авах үед амрах тоглох боломжийг олгосон төдийгүй ариун цэврийн өрөөг засвар хийж тохижууллаа.</p>	
<p>16</p>	<p>Бүртгэлийн ажилтны өдрийг угтаж УБЕГ -аас зохион байгуулсан “Ногоон нэгж “аяны хүрээнд 33 төрлийн 51 цэцэг ургуулж өрөө тасалгааг цэцэгжүүллээ.</p>	
<p>17</p>	<p>Иргэний бүртгэлийн тасаг нь иргэний бүртгэлийн хууль, журам , үнэ тарифын мэдээллийн самбарыг өөрсдийн зардлаар шинэчлэн гаргаж байршууллаа. /178000 төгрөгийн /</p>	<p>Хуучин самбар Шинэ самбар</p> 
<p>18</p>	<p>Иргэний бүртгэлийн тасаг нь хэлтсийн ариуг цэврийн өрөөг өөрсдийн зардлаар шинэчлэн засварлаж тохижуулан ая тухтай нөхцөлийг бүрдүүлсэн. /178000 төгрөгийн /</p>	
<p>19</p>	<p>Албан хаагчдыг чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан.</p>	

**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН**

2024.11.05

Орхон аймаг

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүрт шинэчлэх;</p>	<p>Байгууллагын зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг www.orkhon.burtgel.gov.mn цахим хуудаст 144, https://www.facebook.com/orkhonburtgel фейсбүүк хуудаст 233 мэдээ мэдээлэл болон мэдээллийн самбартаа иргэдэд бүртгэлийн талаарх мэдээллийг ил тод ойлгомжтой байдлаар байршуулсан.</p> <p>Байгууллагын цахим хуудасны нүүр хэсэгт бүртгэлийн болон төрийн цахим үйлчилгээний сайтуудыг байршуулсан</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зүйн дотоод хэргийн яамны https://mojha.gov.mn/, • Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын сайт https://erdenet.mn/medee/, • 2024 оны МУИХ сонгуулийн сонгогчийн мэдээлэлтэй танилцах сайт https://election.burtgel.gov.mn/ • Авлигатай тэмцэх газрын сайт http://iaac.mn/ • Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем. https://e-mongolia.mn/home • Улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээний цахим систем http://burtgel.gov.mn/service/index.php • Улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн http://opendata.burtgel.gov.mn/ • Хуулийн этгээдийн оноосон нэр авах https://e-business.mn/home <p style="text-align: right;">/Зураг 1/</p>	100%
2.	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах</p>	<p>Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, утасны дугаар, өрөөний байршил зэргийг харуулсан мэдээллийг байгууллагын www.orkhon.burtgel.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан.</p> <p>Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн</p>	100%

	цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүрт шинэчлэх;	ил тод байдал шийдвэрлэлтийн мэдээ, тайланг улирлаар гарган иргэдэд нээлттэй хүргэхийн зэрэгцээ аймгийн ЗДТГ болон УБЕГ-т тогтмол хүргүүлэн ажиллаж байна. 7 хоног бүрийн Лхагва гаригт иргэдийг сонсох цаг гаргаж санал хүсэлтийг биеэр, цахимаар сошиалаар, 70358989 утас болон үйлчилгээний зааланд саналын хайрцаг байршуулан авлаа. <i>/Зураг 2/</i>	
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус хэлтсээс иргэдэд үзүүлдэг иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авахад шаардагдах бүрдүүлбэрийн жагсаалт, өргөдлийн загвар болон үнийн мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, мөн бүртгэгч нарын урд QR кодоор авах боломжийг ханган мэдээллийг ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. <i>/Зураг 3/</i>	100%
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус хэлтэс нь мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн бүрдүүлбэр, брошюрыг хэлтсийн мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн самбарыг 2024 оны 10 сард дахин шинэчлэн байршуулсан. Хэлтсийн мэдээллийн самбарт хэлтсийн танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын болон хэлтсийн даргын тушаал, захиргааны байгууллагын шийдвэр, сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, бүртгэлийн үйлчилгээний талаар иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч цаг тухай бүрд мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. <i>/Зураг 4/</i>	100%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох	<ul style="list-style-type: none"> • Хууль зүйн дотоод хэргийн яамны https://moija.gov.mn/, • Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын сайт https://erdenet.mn/medee/ сайтуудыг байгууллагын цахим хуудас болох www.orkhon.burtgel.gov.mn -д холбосноор иргэдийг хуулийн төсөлд саналаа өгөх нөхцөл боломжоор бүрэн хангасан. 	100%

	<p>төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;</p>	<p>/Зураг 5/</p>	
<p>6. Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p>		<p>Иргэдэд цахим үйлчилгээг сурталчилж чадсаны үр дүнд төрийн үйлчилгээний нэгдсэн https://e-mongolia.mn/ систем болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн цогц https://e-business.mn/ портал сайтаар мэдүүлсэн хүсэлтийг цаг алдалгүй шуурхай шалган ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд www.les.e-business.mn системээр шинээр хуулийн этгээдийн оноосон нэрийн 1624 хүсэлт ирснийг хүлээн авч, шалган баталгаажуулсан.</p> <p>www.e-mongolia.mn системээр иргэний шилжилт хөдөлгөөний нийт 919 хүсэлт ирснээс баталгаажсан 567, илгээгдсэн 6, шалгагдсан 11, төлбөр төлсөн 4, бүрдүүлбэр дутуу шаардлага хангахгүй 331 бүртгэлийг хүлээн авахаас татгалзаж хариуг өгсөн.</p> <p>Цахим гадаад паспортын зургийг https://photo.burtgel.gov.mn/ сайтаар хүлээн авахаас гадна хэлтсийн байранд зураг авч үйлчилж байна.</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Дөт" 24/7 киоск 2 ширхэг болон Гэрэгэ киоск 2 ширхэгийг тус тус аймгийн Засаг даргын тамгын газарт байрлах "Цахим төв"-д болон хэлтсийн байранд тус тус байршуулан үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Мөн хэлтсийн үйлчилгээний танхимд гэрэгэ пос машин байршуулан төлбөрийг банк явуулахгүйгээр шийдвэрлэж байна.</p> <p>2024.01.01-2024.10.30-ны өдрийн байдлаар 16 төрлийн 10372 ширхэг лавлагаа, тоон гарын үсэг давхардсан тоогоор 603 иргэнд олгосон байна.</p> <p>Төлбөрийн Гэрэгэ киоск болон пос машинаар 2024.01.02-2024.10.30-ны хооронд иргэний улсын бүртгэлийн 8771, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 3732, хуулийн этгээдийн 781, лавлагааны 5431 болон 193 бүртгэлийн торгуулийн үйлчилгээний төлбөр төлөгдсөн</p>	<p>100%</p>


		байна. Иргэдэд үйлчилгээг шуурхай хүргэх, буцаахгүй байх зорилго тавьж иргэдээс ямар шалтгаанаар буцаадаг тухай санал асуулга авч гарын авлага, мэдээллийг угтах үйлчилгээний ажилтан хариуцан өгдөг болсон. /Зураг 6/	
